

## **СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

Аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын  
2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж  
гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

### **ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮР ДҮН**

Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогыг зохих  
журмын дагуу үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 2017 онд аймгийн хэмжээгээр  
бэлтгэх модны хэмжээ төлөвлөснөөс 35.2 хувиар буурсан байхад түүнээс  
төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт 100.2 хувьтай тайлагнагджээ.

**Сүхбаатар сум**

**2018 оны 07 сар**

## АГУУЛГА

### **Тайланг бэлтгэсэн:**

Сэлэнгэ аймаг дахь  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор  
Ч.Энхтуяа

Аудитын менежер  
Б.Батмөнх

Ахлах аудитор  
Ц.Отгонбаяр  
С.Бат-Эрдэнэ

Аудитор  
Б.Эрдэнэзул

Аудитын  
тайлан, дүгнэлттэй  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл гарвал  
70362442, 70363047,  
70363040 дугаарын  
утас, **Selenge**  
**@audit.gov.mn** мэйл  
хаягаар харилцана уу.

**ХАЯГ:** Сэлэнгэ аймгийн  
ЗДТГ-ын байрны  
өргөтгөлд

2018 оны 7 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар  
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй  
Үндсэн мэдээлэл  
Аудитын дүн

### **1. Ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээ, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, хуваарилалт үр дүнтэй байна уу?**

1.1 Ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээ, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж байна уу?

1.2 Аймаг, сумдын ИТХ нь ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээг журмын дагуу хуваарилан, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг баталж байна уу?

### **2. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байна уу?**

2.1 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөсний дагуу бүрэн төвлөрүүлж байна уу?

2.2 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтэд үр нөлөө бүхий хяналт хийгдэж байна уу?

Илрүүлсэн зөрчил

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>ААН</b>	Аж ахуйн нэгж байгууллага
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын яам
<b>БОАЖС</b>	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
<b>БОАЖГ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын газар
<b>БОУБ</b>	Байгаль орчны улсын байцаагч
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>ИНХ</b>	Иргэдийн Нийтийн хурал
<b>МБҮ</b>	Мод бэлтгэлийн үйлдвэр
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>УБТЗ</b>	Улаанбаатар төмөр зам

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

### 1. Аудит хийх үндэслэл

Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

### 2. Аудитын зорилт

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, үр дүнд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 1. Ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээ, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, хуваарилалт үр дүнтэй байна уу?*
- 2. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байна уу?*

### 3. Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, аймгийн БОАЖГ, сум дундын болон сумын ойн ангийн дарга, холбогдох мэргэжилтнүүд, аймаг, сумдын Засаг дарга, сумдын санхүүгийн албаны дарга нар, татварын байцаагч, байгаль орчны улсын байцаагч зэрэг албан тушаалтнууд, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны 2017 оны орлого бүрдүүлэлт, төлөвлөлт, хуваарилалт, хяналт, тайлагналтай холбоотой эрх зүйн актууд болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримт, материалуудыг хамруулав.

### 4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

### 5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль ,

- Ойн тухай хууль ,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль ,
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-153 дугаар тушаалаар батлагдсан "Гарал үүслийн гэрчилгээ олгох хяналт тавих журам",
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-53 дугаар тушаалаар батлагдсан "Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам",
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/166 дугаар тушаалаар батлагдсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам",
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан "Ойгоос мод бэлтгэх журам",
- Дээрх хууль, журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад хууль эрхийн актууд.

## **6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, С.Бат-Эрдэнэ, аудитор Б.Эрдэнэзул нар 2018 оны 05 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

## **ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 126 дугаар тогтоолоор сум дундын ойн ангиудыг байгуулсан байна.

Уг тогтоолд Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийг Ерөө суманд, Хараагийн бүсийн сум дундын ойн ангийг Мандал суманд, Орхоны бүсийн сум дундын ойн ангийг Баруунбүрэн суманд, Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн ангийг Сүхбаатар суманд тус тус байршуулан байгуулжээ. Аймгийн ИТХ-ын 2013 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 105 дугаар тогтоолоор Сэлэнгэ-Бэлчирийн бүсийн сум дундын ойн ангийг Цагааннуур суманд байршуулахаар өөрчлөлт оруулсан байна.

Хүдэр сумын ИТХ-ын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 116 дугаар тогтоолоор "Хүдэр сумын ойн анги" ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2017 онд ойгоос хэрэглээний мод 79130 м3, түлээний мод 84005 м3 бэлтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр хэрэглээний мод 56817,3 м3 , түлээний мод 48964,5 м3 бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогод 771,253.9 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 773,147.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл 100.2 хувьтай тайлагнагдсан байна.

## АУДИТЫН ДҮН

### Бүлэг 1

**Ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээ, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, хуваарилалт үр дүнтэй байна уу?**

*Зарим сумын ИТХ нь ойгоос бэлтгэх мод, түлээний тоо хэмжээг байгууллага, нөхөрлөл тус бүрээр бус бөөн дүнгээр баталсан байна.*

**1.1 Ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээ, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж байна уу ?**

*Аймгийн Засаг даргаас 2017 онд ойгоос бэлтгэх модны саналыг БОАЖС-д хүргүүлсэн боловч, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй, саналыг бүх сумдаас бүрэн аваагүй байна.*

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх тухай журам”-ын 2.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд заасан жилд бэлтгэх модны боломжит хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр, сумдын саналыг үндэслэн өөрийн аймгийн ойн сангаас дараа жилд бэлтгэх модны талаарх саналаа Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ” гэж заасан байдаг.

Сэлэнгэ аймгийн Засаг дарга нь сумдаас ирүүлсэн саналыг үндэслэн аймгийн хэмжээнд 2017 онд ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээний талаарх саналыг батлагдсан маягтын дагуу боловсруулж, 2016 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 1/422 дугаар албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.

Аудитын явцад 2017 онд ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээний талаарх сумдаас ирүүлсэн болон түүнийг нэгтгэн БОАЖЯ-нд хүргүүлсэн аймгийн санал, тэдгээрийн үндэслэлд тулган баталгаажуулалт хийж үзэхэд Ерөө, Хүдэр, Мандал, Зүүнбүрэн, Хушаат зэрэг сумдын ирүүлсэн санал нь албан бичиг болон бусад баримт материалаар нотлогдохгүй байсан бөгөөд аймгийн ойн менежментийн төлөвлөгөөний хугацаа 2016 онд дууссан байхад дахин боловсруулсан төлөвлөгөөг БОАЖЯ-ны холбогдох албан тушаалтнуудаар баталгаажуулаагүй байлаа.

Эдгээр нь ойн сангаас бэлтгэх модны төлөвлөгөөнд сумдын санал бүрэн тусгагдахгүй байх, бэлтгэх модны төлөвлөлт аймгийн ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн Засаг даргаас БОАЖЯ-д хүргүүлсэн саналд 2017 онд аймгийн хэмжээнд бэлтгэх хэрэглээний модыг 109680 м<sup>3</sup>, түлээний модыг 100600 м<sup>3</sup> –ээр тусгаж, Засгийн газрын 2014 оны 307 дугаар тушаалаар баталсан “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын дагуу төсвийн орлогыг 669,967.8 мянган төгрөг байхаар тооцсон байна.

Дээрх саналд үндэслэн Сэлэнгэ аймгийн ойн сангаас 2017 онд бэлтгэх модны дээд хязгаарыг хэрэглээний мод 74988 м3, түлээний мод 90402 м3, нийт дүнгээр 165390 м3 байхаар хянаж, БОАЖС-ын 2016 оны 11 сарын 23-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталгаажуулан ирүүлсэн нь аймгийн Засаг даргаас явуулсан саналаас хэрэглээний модыг 34692 м3, түлээний модны хэмжээг 10198 м3 –ээр тус тус бууруулсан байна. / Сэлэнгэ аймгийн хүргүүлсэн санал, БОАЖЯ-аас баталсан дараа жилд бэлтгэх модны дээд хэмжээ болон ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг Хавсралт 1-д дэлгэрэнгүйгээр харуулав /

**1.2 Аймаг, сумдын ИТХ нь ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээг журмын дагуу хуваарилан, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг бодитоор баталж байна уу?**

Сумдын ИТХ нь ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг аж ахуйн нэгж, нөхөрлөл тус бүрээр бус бөөн дүнгээр баталсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар Сэлэнгэ аймагт 2017 онд ойн сангаас бэлтгэх модны дээд хязгаарыг 165390 м3-ээр, улсын тусгай хамгаалалттай газрын ойн сангаас бэлтгэх модны дээд хязгаарыг 7000 м3-ээр, ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд бэлтгэх модны дээд хязгаарыг 109360 м3-ээр буюу нийт 281750 м3-ээр тогтоожээ.

БОАЖС-ын хянаж ирүүлсэн дээд хязгаарт үндэслэн аймгийн ИТХ нь 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02, 07 дугаар сарын 27-ны өдрийн 97 дугаар тогтоолуудаар 2017 онд аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны хэмжээг **275790 м3**- байхаар / ойн цэвэрлэгээ хөтөлбөр орсон дүн / баталж, сумдад хуваарилсан байна.

Аймгийн ИТХ-аас баталж, сумдад хуваарилсан дээд хязгаарт үндэслэн сумдын ИТХ-аас 2017 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг нийт 163135 м3-ээр тогтоож, баталсан байна. Аймгийн ИТХ болон сумдын ИТХ-аас баталсан ойн сангаас бэлтгэх модны тоо хэмжээг сум тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт 1 /м3-ээр/

№	Сумын нэр	Бэлтгэх сумын нэр	Аймгийн ИТХ-аар			Сумын ИТХ-ын тогтоолоор		
			Хэрэглээ	Түлээ	Дүн	Хэрэглээ	Түлээ	Дүн
1	Алтанбулаг	Өөрийн сумаас	1200	5,270	6,470	1200	5100	6300
2	Сүхбаатар	Алтанбулаг		12,000	12,000		3000	3000
		Хүдэр		6,000	6,000	0	0	0
		Түшиг		12,000	12,000		12000	12000
3	Шаамар	Өөрийн сумаас	300	50	350		405	405
		Алтанбулаг	1000	1,400	2,400	1000	1400	2400
		Хүдэр		1,000	1,000	0	800	800
4	Ерөө	Өөрийн сумаас	33384	39,496	72,880	26750	13480	40230
5	Хүдэр	Өөрийн сумаас	19950	13,740	33,690	19950	13740	33690
6	Зүүнбүрэн	Түшиг	1000	2,600	3,600	1000	2450	3450
7	Цагааннуур	Өөрийн сумаас	3500	4,170	7,670	3500	4170	7670
8	Түшиг	Өөрийн сумаас	7800	2,860	10,660	7000	2810	9810
9	Хушаат	Өөрийн сумаас	1700	1,900	3,600	1650	1950	3600
10	Жавхлант	Ерөө		1,000	1,000	0	1000	1000
		Өөрийн сумаас		200	200		200	200
11	Орхон	Баруунбүрэн		1,500	1,500		1500	1500
		Сант		1,500	1,500			0
12	Орхонтуул	Баруунбүрэн		1,700	1,700		1700	1700
13	Баянгол	Ерөө		100	100			0
		Өөрийн сумаас		4,000	4,000			0
14	Мандал	Өөрийн сумаас	31220	39,870	71,090	14380	9170	23550
15	Сайхан	Баруунбүрэн	1000	2,050	3,050	500	2050	2550
		Сант		2,050	2,050			0
16	Сант	Өөрийн сумаас	1000	3,450	4,450	500	3200	3700
17	Баруунбүрэн	Өөрийн сумаас	1950	3,880	5,830	1700	3880	5580
	Тужийн нарсны болон Хан Хэнтий БЦГ			7,000	7,000			
<b>Нийт дүн</b>			<b>105,004.00</b>	<b>170,786</b>	<b>275,790</b>	<b>79130</b>	<b>84005</b>	<b>163135</b>

БОАЖС - ын хянаж ирүүлсэн 2017 онд аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, сумдын ИТХ- аар хэрхэн баталсныг харьцуулан харуулбал:

Хүснэгт 2 /м3-ээр/

д/д	Үзүүлэлт	БОАЖС-ын тушаалаар аймагт хуваарилсан дүн	Аймгийн ИТХ-аас сумдад хуваарилсан дүн	Зөрүү илүү/ (дутуу)	Сумдын ИТХ-аас хуваарилсан дүн	Аймаг болон сумын ИТХ баталсан Зөрүү илүү/ (дутуу)
1	Ойн сангаас бэлтгэх модны дээд хязгаар /м.куб/	165,390.0	159,430.0	(5,960.0)	129,875.0	(29,555.0)
2	Улсын тусгай хамгаалалттай газрын ойн сангаас бэлтгэх модны дээд хязгаар /м.куб/	7,000.0	7,000.0	-	-	-
3	Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар /м.куб/	109,360.0	109,360.0	-	33,260.0	(76,100.0)
Нийт дүн		281,750.0	275,790.0	(5,960.0)	163,135.0	(105,655.0)

Хүснэгтээс харахад 2017 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг БОАЖС-аас 281750 м3 –ээр хянаж ирүүлсэн бол аймгийн ИТХ-аар 275790 м3-ээр, сумдын ИТХ-аар 163135 м3 -ээр тус тус эцэслэн баталсан нь хянагдаж ирсэн хязгаараас 112655 м3-ээр буюу 40,8 хувиар буурсан байна.

Ойн тухай хуулийн 32.3-д “Сумын ИТХ нь дараа жилд бэлтгэх модны хэмжээг ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөө болон иргэдийн хэрэгцээг үндэслэн дараах байдлаар тогтооно “ Үүнд:

- ✓ үйлдвэрлэлийн ашиглалт явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн огтлолтыг байгууллага бүрээр;
- ✓ ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг байгууллага бүрээр;
- ✓ ойн нөөц бүхий аймаг, сумын иргэдийн ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын огтлолтыг баг бүрээр” гэж заасан байдаг.

Гэтэл зарим сумдын ИТХ-аас ойгоос мод, түлээ бэлтгэх байгууллага, нөхөрлөлийг нэр тус бүрээр нь бус бөөн дүнгээр, тодорхойгүй байдлаар баталсан байна. Үүнд:

- ✓ Алтанбулаг сум нөхөрлөлүүдийн, Түшиг сум нөхөрлөл, иргэдийн бэлтгэх модны хэмжээг бөөн дүнгээр,
- ✓ Ерөө сум ямар байгууллага бэлтгэх нь тодорхойгүй “Үлдэгдэл” нэрээр 3820 м3 хэрэглээний мод,
- ✓ Мандал сум ахуйн зориулалтаар иргэдийн хэрэгцээнд нэрээр 2660 м3 хэрэглээний модыг бөөн дүнгээр,



- ✓ Баруунбүрэн сумаас Орхонтуул, Орхон сумдын, Алтанбулаг сумаас Сүхбаатар, Шаамар сумдын бэлтгэх модны хэмжээг бөөн дүнгээр,
- ✓ Сант сум мод бэлтгэх аж ахуй нэгж, иргэнийг зааглаагүй бөөн дүнгээр,
- ✓ Хүдэр сум уламжлалт бүтээгдэхүүн, нөөц нэрээр 2900 м3-ыг, ойн менежментийн төлөвлөгөөгүй, хугацаа нь дууссан, ойн ашиглалтын талбайгүй зэрэг 15 аж ахуйн нэгж, 18 нөхөрлөлд 5771 м3 мод бэлтгэх хуваарийг тус тус баталсан,
- ✓ Баянгол сумын ИТХ нь өөрийн нутаг дэвсгэрээс бэлтгэх түлээний модны хэмжээг батлаагүй байна.

БОАЖС-ын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх тухай журам”-ын 2.7-д “ Сумын ИТХ-аас ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар багт хуваарилсан модыг Багийн Нийтийн Хурал багийн Засаг даргын саналыг үндэслэн иргэдэд хуваарилана ” гэж заасныг зөрчиж, сумын ИТХ-аас ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар багт хуваарилсан модыг багийн Нийтийн хурал болон багийн Засаг даргын саналыг үндэслэлгүйгээр сумын сумын Засаг даргын цохолтоор иргэдэд олгосон байна.

Сумдын ИТХ-аас ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг Сүхбаатар, Сайхан, Орхонтуул сумдаас бусад 14 суманд анх 471,759.3 мянган төгрөгөөр баталсан бөгөөд бэлтгэх модны дээд хязгаарт өөрчлөлт ороогүй байхад орлогын төлөвлөгөөнд 2-4 удаагийн тодотгол хийн 299,494.6 мянган төгрөгөөр буюу 63.5 хувиар нэмж, 771,253.9 мянган төгрөгөөр баталжээ.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд сумдын ИТХ-нь дараа жилд бэлтгэх модны тоо, хэмжээг хуваарилан батлахдаа аж ахуйн нэгж, нөхөрлөл, баг бүрээр нэр заан тодорхой байдлаар тусгаагүй, ойн мэргэжлийн байгууллагын болон багийн ИНХ, багийн Засаг даргын санал, тооцооллыг үндэслээгүй байгаа нь тухайн жилд ойн сангаас бэлтгэх модны дээд хэмжээ, мод түлээ ашигласны төлбөрийн орлого бодитой төлөвлөгдөхгүй байх нөхцөл болж байна.

Аймаг, сумын хэмжээнд дараа жил бэлтгэх модны дээд хэмжээг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хуваарийг үндэслэн аймгийн ИТХ тухайн оны 10 дугаар сарын 10-ны дотор, сумын ИТХ 12 дугаар сарын 10-ны дотор багтаан баталж байхаар тус тус зохицуулагджээ.

Гэвч Сэлэнгэ аймагт 2017 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг баталсан БОАЖС-ын тушаал нь журамд заасан хугацаанаас 4 сарын дараа батлагдаж ирснээс шалтгаалан аймгийн ИТХ 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр, сумдын ИТХ 1-2 сарын дараа буюу 2017 оны 01 сарын 19-нөөс 2 дугаар сарын 13-ны өдрийн хооронд тус тус баталсан байна.

Мод бэлтгэх дээд хязгаарыг журамд заасан хугацаанд батлахгүй байгаа нь тайлант онд бэлтгэх модны хэмжээ батлагдсан хэмжээнээс хэтрэх, мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг бодитоор тооцож, батлахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

## Бүлэг 2

**Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байна уу?**

*Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл болон үнэт цаасны зарцуулалтад хяналт, шалгалт хийгдэхгүй байна.*

### 2.1 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөсний дагуу бүрэн төвлөрүүлж байна уу?

*Зарим сум хуулийн дагуу ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг урьдчилан төлүүлээгүйгээс их хэмжээний төлбөрийн тооцоо үүссэн байна.*

Төсвийн тухай хуулийн 23.8.7-д ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг сумын төсвийн татварын орлогын бүрэлдэхүүн байхаар хуульчилсан байдаг.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2017 онд ойгоос хэрэглээний мод 79130 м3, түлээний мод 84005 м3 бэлтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр хэрэглээний мод 56817,3 м3 , түлээний мод 48964,5 м3-ыг бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогод 771,253.9 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 773,147.3 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 100.2 хувиар биелсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

*Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын 2017 оны гүйцэтгэл*

*Хүснэгт 3*

№	Сумын нэр	Бэлтгэх сумын нэр	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Хувь
			Хэрэглээ /м3 /	Түлээ /м3/	мөнгөн дүн /мян.төгрөг/	Хэрэглээ / м3 /	Түлээ /м3/	мөнгөн дүн /мян.төгрөг/	
1	Алтанбулаг	Өөрийн сумаас	1200	5100	26,567.00	886	3737	40,486.80	152.40
2	Сүхбаатар	Алтанбулаг	0	3000	-	0	3198	-	
		Хүдэр	0	0		0	0		
		Түшиг	0	12000		0	2230		
3	Шаамар	Өөрийн сумаас	0	405	200.00	0	405	1,579.50	789.75
		Алтанбулаг	1000	1400		864	8		
		Хүдэр	0	800		0	65		
4	Ерөө	Өөрийн сумаас	26750	13480	245,317.30	18078.5	5261.9	202,426.40	82.52
5	Хүдэр	Өөрийн сумаас	19950	13740	202,692.90	16568	7869	249,899.40	123.29
6	Зүүнбүрэн	Түшиг	1000	2450	2,000.00	0	1041	1,365.10	68.26
7	Цагааннуур	Өөрийн сумаас	3500	4170	34,233.20	2750	2640	37,034.10	108.18
8	Түшиг	Өөрийн сумаас	7000	2810	43,170.90	4712	1805	49,791.80	115.34
9	Хушаат	Өөрийн сумаас	1650	1950	11,294.40	697.3	1779.7	6,234.00	55.20
10	Жавхланта	Ерөө	0	1000	400.00	0	554	550.20	137.55
		Өөрийн сумаас	0	200		0	168		
11	Орхон	Баруунбүрэн	0	1500	100.00	0	944	6.00	6.00
		Сант	0	0		0	0		
12	Орхонтуул	Баруунбүрэн		1700	-		58	-	3.41
13	Баянгол	Ерөө	0	0	2,023.50	0	0	1,925.80	95.17
		Өөрийн сумаас	0	0		0	710		
14	Мандал	Өөрийн сумаас	14380	9170	163,132.10	10048.1	8706.4	143,176.90	87.77
15	Сайхан	Баруунбүрэн	500	2050	-	760	757	9.10	
		Сант	0	0		0	0		
16	Сант	Өөрийн сумаас	500	3200	8,000.00	114	3608.3	7,902.70	98.78
17	Баруунбүрэн	Өөрийн сумаас	1700	3880	32,122.60	1339.4	3419.2	30,759.50	95.76
<b>Нийт дүн</b>			<b>79130</b>	<b>84,005.00</b>	<b>771,253.90</b>	<b>56,817.30</b>	<b>48,964.50</b>	<b>773,147.30</b>	<b>100.25</b>

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөрийн орлогын 77,0 хувь буюу 595,502.7 мянган төгрөгийг Ерөө, Хүдэр, Мандал сумд бүрдүүлсэн байна. Үүнд:

- ✓ *Ерөө сум 245,317.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 202,426.4 мянган төгрөг,*
- ✓ *Хүдэр сум 202,692.9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 249,899.4 мянган төгрөг,*
- ✓ *Мандал сум 163,132.1 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 143,176.9 мянган төгрөг тус тус төвлөрүүлжээ.*

Аудитын явцад орлогын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. *Сайхан сум Баруунбүрэн сумын ИТХ-ын тогтоолгүйгээр тус сумын нутаг дэвсгэрээс 260 м3 хэрэглээний мод, Баянгол сум ИТХ-ын тогтоолгүйгээр өөрийн сумын нутаг дэвсгэрээс 710 м3 түлээний мод тус тус бэлтгэсэн байна.*
2. *Мөн сумдын мод бэлтгэлийн гүйцэтгэлийг аж ахуйн нэгж, нөхөрлөл бүрээр тулгаж үзэхэд Ерөө сумын Сосна ХХК нь 240 м3 буюу 2,052.0 мянган төгрөгийн хэрэглээний модыг ИТХ-аар баталсан хэмжээнээс илүү бэлтгэсэн байна.*

Ойн тухай хуулийн 33.1 дэх заалт болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 2.12 дахь заалтыг үндэслэн ойн анги нь мод бэлтгэх эрх авсан нөхөрлөл, ААН-тэй гэрээ байгуулан ажиллах ёстой байдаг.

Ойн ангиудын 2017 онд мод бэлтгэсэн нөхөрлөл, ААН-тэй байгуулсан гэрээг авч үзвэл:

Хүснэгт 4

□	Ойн ангийн □□□	ААН-ийн тоо			Нөхөрлөл-ийн тоо		
		гэрээ байгуулах ёстой	гэрээ байгуулсан	гэрээ байгуулаагүй	гэрээ байгуулах ёстой	гэрээ байгуулсан	гэрээ байгуулаагүй
1	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	9	9	0	4	4	0
2	Ерөө бүсийн сум дундын ойн анги	23	18	5	8	8	0
3	Хүдэр сумын ойн анги	21	21	0	24	24	0
4	Хараа бүсийн сум дундын ойн анги	21	21	0	29	29	0
5	Орхон бүсийн сум дундын ойн анги	5	3	2	13	12	1
□□□□□□		<b>79</b>	<b>72</b>	<b>7</b>	<b>78</b>	<b>77</b>	<b>1</b>

Хүснэгтээс харахад Ерөө бүсийн сум дундын ойн анги 5 ААН, Орхон бүсийн сум дундын ойн анги 2 ААН, 1 нөхөрлөлтэй гэрээ байгуулаагүй байна. Үүнд:

- *Баруунбүрэн сумын 2 ААН, 1 нөхөрлөл 329.2 м3 буюу 1,838.2 мянган төгрөгийн,*

- Ерөө сумын 5 ААН 2955 м3 буюу 22,616.5 мянган төгрөгийн зэрэг нийт 3284.2 м3 буюу 24,454.7 мянган төгрөгийн модыг гэрээ байгуулаагүй бэлтгэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 3.2-д "Ойгоос мод бэлтгэх эрх авсан нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага мод бэлтгэх талбайг Ойн ангиар тусгаарлуулж, мөнгөн үнэлгээ хийлгэсэн байна", 3.3-д "Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, "Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг"-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна" гэж заасан байдаг.

Гэтэл сум дундын болон сумын ойн анги мод бэлтгэх эрх авсан нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мод бэлтгэх талбайг тусгаарлаж өгөөд, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлсний дараа мод бэлтгэх эрхийн бичгийг олгоогүйгээс ихээхэн хэмжээний төлбөрийн авлага, өглөг үүссэн байна.

2017 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг мод бэлтгэх эрхийн бичиг, төрийн сангийн хуулга, төлбөр тушаасан баримт, ойн ангиудын мод бэлтгэлийн тайлан, мэдээтэй тулгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Мандал сумын 9 ААН, нөхөрлөл 564.3 мянган төгрөгийг дутуу, 10 ААН, нөхөрлөл 5,747.2 мянган төгрөгийг илүү,
- Алтанбулаг сумын 3 ААН 1876.0 мянган төгрөгийг илүү,
- Цагааннуур сумын 3 ААН 7,737.5 мянган төгрөгийг илүү,
- Сайхан сумын 1 ААН 584.3 мянган төгрөгийг илүү,
- Баруунбүрэн сумын 1 ААН 1,999.5 мянган төгрөгийг илүү,
- Хүдэр сумын 1 ААН, нөхөрлөл 1,440.0 мянган төгрөгийг дутуу, 2 ААН, нөхөрлөл 1809.9 мянган төгрөгийг илүү
- Ерөө сумын 15 ААН, нөхөрлөл 76,804.1 мянган төгрөгийг дутуу, 16 ААН, нөхөрлөл 40,526.2 мянган төгрөгийг илүү төлсөн байна.

Их хэмжээний тооцоо үүсгэсэн Ерөө бүсийн сум дундын ойн ангитай холбоотой зөрчлийг задалж харуулбал: /Дэлгэрэнгүйг хавсралт 2-д үзүүлэв./:

1. Ойн нөөц ашигласны төлбөрийг талбай тусгаарлалтын материалыг үндэслэн тухай бүрд нь урьдчилан төлүүлээгүйгээс 2016 оны эцэст 16 ААН, нөхөрлөл 56,640.7 мянган төгрөгийг дутуу, 7 ААН, нөхөрлөл 3,451.2 мянган төгрөгийг илүү төлж, нийт дүнгээр 53,189.6 мянган төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн байна.
2. 2017 оны жилийн эцэст үүссэн 76,804.1 мянган төгрөгийн авлага, 40,526.2 мянган төгрөгийн өглөгт дүн шинжилгээ хийж үзэхэд:
  - 2016 оны жилийн эцсийн байдлаар үүссэн авлагаас бүтэн 1 жилийн хугацаа өнгөрсөн байхад нэг ч төгрөгийн төлөлт хийгээгүй 5 ААН, нөхөрлөлийн нийт 14,863.0 мянган төгрөгийн авлага байна. Үүнд: /"ЭБНЗ" ХХК 9,699.6 мянган төгрөг, Мөнхтөгөл нөхөрлөл 1,480.6 мянган төгрөг, Гурван гол нөхөрлөл 1,080.1 мянган төгрөг, Бугант говь ХХК 1,432.1 мянган төгрөг, Төгөлдөр хангай ХХК 1,170.6 мянган төгрөг /

- 2017 онд сумын ИТХ-ын тогтоолоор мод бэлтгэх эрх аваагүй Номин од ХХК-д 10,012.7 мянган төгрөгийн, Иенбирс ХХК-д 1,781.3 мянган төгрөгийн, Цант ажнай ХХК-д 2456,7 мянган төгрөгийн, Төгөлдөр хангай ХХК-д 1,170.6 мянган төгрөгийн мод бэлтгэх эрхийн бичиг олгосон байна. Үүнээс тайлант оны эхэнд Номин од ХХК нь 20,080.2 мянган төгрөгийн, Цант ажнай ХХК нь 3,307.4 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байсан бөгөөд тайлант онд нэмж мод бэлтгэсэн боловч нэг ч төгрөгийн төлөлт хийгээгүй байна.
- Номин од ХХК нь тайлант оны эцэст 30,092.9 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байгаа нь нийт авлагын 39.2 хувийг эзэлж байна.
- 2017 онд сумын ИТХ-ын тогтоолоор мод бэлтгэх эрх авсан боловч тайлант оны эхэнд дутуу төлөлттэй 2 компанид ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүй мод бэлтгэх эрхийн бичиг нэмж олгосноор Ар санжинт ХХК нь 6,699.8 мянга, Өгөөж хараа ХХК нь 6,064.2 мянган төгрөгийн дутуу төлөлттэй болж авлагын дүнг өсгөсөн байна.

2017 оны эцэст үүссэн илүү төлөлттэй 4 ААН-тэй холбоотой өглөгийн дүнг тус ойн ангиас тодруулахад *“Илүү төлөлт байх ёсгүй, эдгээр байгууллагууд сумын ИТХ-аар батлагдсан хэрэглээ, түлээг 100 хувь бэлтгэсэн байхад эрхийн бичгийн дүнгээр дутуу бэлтгэсэн харагдаж байна. Аудит дууссаны дараа эрхийн бичгийн дүнг дахин нягтлах шаардлагатай байна.”* гэсэн тайлбар өгсөн учир төлбөрийн тооцоог дахин тулган шалгах нь зүйтэй юм.

Дээрх авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,* 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Үүнээс үзэхэд ойн ангиуд нь мод бэлтгэх эрхийн бичгийн тайланг бүрэн хөтлөөгүй, талбай тусгаарлалт хийсний дараа мод бэлтгэгч ААН, нөхөрлөлөөр ойн нөөц ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүйгээр эрхийн бичиг олгосон, их хэмжээний төлбөрийн орлогын тооцоо үүсгэсэн зэрэг нь ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого бүрэн төлөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

## **2.2 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтэд үр нөлөө бүхий хяналт, шалгалт хийгдэж байна уу?**

*Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй бөгөөд эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний үлдэгдлийг ойн ангийн санхүүгийн тайланд тусгаагүй байна.*

Ойн тухай хуулийн 17.3.6-д аймгийн БОАЖГ нь ойн нөөц ашигласны төлбөр, хураамжийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төвлөрүүлэхэд, 18.3.7-д сум дундын болон сумын ойн анги нь ойн нөөц ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж, тэдгээрийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахаар тус тус заасан байна.

БОАЖС-ын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 9.1-д *“сумын Засаг даргын томилсон албан тушаалтан ойгоос мод бэлтгэсэн ажлын тайланг гаргаж, Ойн анги хянаж нэгтгэн тухайн оны 12 сарын 01-ний дотор аймгийн БОАЖГ-т хүргүүлнэ”, 9.2-д “аймгийн Засаг дарга тухайн жилд ойгоос бэлтгэсэн мод, ойн нөөц ашигласны төлбөрөөс орсон орлогын тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор БОАЖЯ-нд хүргүүлнэ”* гэж заасан байна.

Дээрх заалтын дагуу аймгийн БОАЖГ-ын гаргасан мэдээгээр 2017 онд аймгийн дүнгээр нийт 36995.7 м3 хэрэглээний мод, 34795.6 м3 түлээний мод бэлтгэж, 471,759.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн гэж тайлагнажээ.

Аудитын явцад ойн ангиудын бэлтгэсэн модыг эрхийн бичиг болон төрийн сангийн хуулга, сумдын төрийн сангаар баталгаажуулсан татварын орлогын гүйцэтгэлтэй тулгаж үзэхэд 2017 онд аймгийн дүнгээр нийт 79130 м3 хэрэглээний мод, 86205 м3 түлээний мод бэлтгэж, 773,147.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Дээрх 2 тоо, мэдээг хүснэгтээр зэрэгцүүлэн харуулбал:

Хүснэгт 5

□	Мэдээ, тайлан бэлтгэсэн байгууллагын нэр	Гүйцэтгэл		
		Хэрэглээ / м3 /	Түлээ /м3/	мөнгөн дүн /мян.төгрөг/
1	Аймгийн БОАЖГ	36995.7	34795.6	484,985.90
2	Аудитын дүнгээр /Сумдын ойн ангиудын дүнг нэгтгэсэн /	56817.3	48964.5	773,147.30
<b>Зөрүү</b>		<b>19,821.6</b>	<b>14,168.9</b>	<b>288,161.40</b>

Аймгийн БОАЖГ нь журмын дагуу сум болон ойн ангиудаас тухайн оны 12 дугаар сарын 01-ны дотор тоо, мэдээг авч нэгтгэснээс, өөрөөр хэлбэл тайлант оны сүүлийн 1 сарын мод бэлтгэлийн ажлын тайланг орхигдуулснаас гадна тайлан мэдээг, албан ёсоор баталгаажуулж, бодитоор авч нэгтгээгүй зэргээс шалтгаалан БОАЖГ болон аудитаар түүвэрлэсэн бэлтгэсэн модны тоо хэмжээ 33,990,5 м3- ээр, төвлөрүүлсэн орлого 288,161.4 мянган төгрөгөөр зөрж байна.

Ойн ангиудаас авсан мэдээ, тайланг хэрхэн нэгтгэсэн талаар БОАЖГ-ын ойн албаны мэргэжилтэн Э.Энхтулгаас тодруулахад *“Сумдын ойн ангиудаас мэдээ тайланг цахим шуудангаар авч нэгтгэсэн, зарим ойн ангиуд мэдээ тайлангаа хугацаандаа гаргаж өгдөггүйгээс мод бэлтгэлийн ажлын тайланг ойн ангиас, орлогын гүйцэтгэлийг сумдын төрийн сангаас авдаг, энэ нь мэдээ тайланг нэгтгэхэд хүндрэл үүсгэдэг.”* гэсэн тайлбар өгсөн бөгөөд нэг ч ойн анги мэдээ, тайланг албан бичиг, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж өгөөгүй байгаа нь аймгийн хэмжээний жилийн эцсийн мэдээ, тайлан алдаатай, зөрүүтэй нэгтгэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

Иймд аймгийн БОАЖГ нь ойн ангиудын мэдээ тайланг холбогдох маягтуудын дагуу, албан ёсоор баталгаажуулан авч, бэлтгэсэн модны хэмжээнд хяналт шалгалт хийж, хариуцлага тооцон ажиллах нь зүйтэй юм.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг тулгах үндсэн баримт нь мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ байдаг.

Аудитаар ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг шалгахдаа мод бэлтгэх эрхийн бичгийн дүнг үндэслэсэн бөгөөд аудит хийх цаг хугацаа, хүн хүч дутмаг байдлаас шалтгаалан гарал үүслийн гэрчилгээ олголтыг шалгаж үзээгүй болно.

Ойн ангиудын 2017 онд олгосон мод бэлтгэх эрхийн бичгийн тайланг авч үзвэл:/

Хүснэгт 6 /ширхэгээр /

№	Ойн ангийн нэр	эхний үлдэгдэл	орлого	зарлага	эцсийн үлдэгдэл
1	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	750	4600	5000	350
2	Ерөө бүсийн сум дундын ойн анги	900	1395	1642	653
3	Хүдэр сумын ойн анги	100	800	597	303
4	Хараа бүсийн сум дундын ойн анги	0	1542	1101	441
5	Орхон бүсийн сум дундын ойн анги	400	2500	2150	750
	дүн	2150	6237	5490	2897

Ойн тухай хуулийн 18.2.3-д сумын Засаг дарга эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг олгоход хяналт тавих, уг эрхийн бичиг, гэрчилгээг үндэслэлгүй олгосон нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгохоор заасан байдаг.

Ойн ангиудын эрхийн бичиг олголтод хэн, хэрхэн хяналт тавьж, мэдээ тайланг гаргаж байгаа талаар сумын Санхүүгийн албаны дарга нараас тодруулахад “ Сумдын татварын байцаагч нар ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлд хяналт тавьдаг, БОУБ эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт, бичилтэд хяналт тавьдаг, ойн анги эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг олгож, мэдээ тайланг гаргадаг.” гэсэн тайлбаруудыг өгч байлаа.

Ойн ангийн нягтлан бодогч нараас тодруулахад “ Манай байгууллагын дансанд орлого нь төвлөрдөггүй, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний тооцоог ойн ангийн инженер, эсвэл нярав хариуцдаг учир орлогын гүйцэтгэлийг шалгадаггүй, үнэт цаас, гарал үүслийн гэрчилгээний тооцоог тулгадаггүй, санхүүгийн тайлан балансад мөн тусгадаггүй гэсэн тайлбарыг өгч байлаа.”

Дээрх тайлбаруудаас харахад мод бэлтгэх эрхийн бичгийн хөдлөл өөрчлөлт, үлдэгдэл түүнээс төвлөрүүлэх төсвийн орлогын гүйцэтгэлд сумын албан тушаалтнуудаас тодорхой хяналт тавьдаггүй нь тодорхой бөгөөд үүнээс шалтгаалан

их хэмжээний татварын орлогын тооцоо үүссэнийг актаар баталгаажуулаагүй, эрхийн бичгийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй байна.

Цаашид сумдын Засаг даргын зүгээс ойн нөөцийн орлогын дансны хуулгын боловсруулалтад анхаарч, мод бэлтгэх эрхийн бичиг олголт, түүнээс төвлөрүүлэх төсвийн орлогын гүйцэтгэлд татварын байцаагч болон Санхүүгийн албаны дарга нараар тогтмол хяналт тавиулж байх шаардлагатай байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-153 дугаар тушаалаар батлагдсан "Гарал үүслийн гэрчилгээ олгох хяналт тавих журам"-ын 5.7-д *"Ойн анги, сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт, үлдэгдлийн тайланг улирал тутамд гаргаж, улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Байгаль орчны газарт, Байгаль орчны газар нь тухайн сарын 15-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ."* гэж заажээ.

Сум дундын болон сумын ойн анги эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтыг тайланг аймгийн БОАЖГ-т улирал бүрийн 10-ны дотор гаргаж өгч байгаа боловч, тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажсан албан бичгээр бус цахим шуудангаар хүргүүлсэн байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-153 дугаар тушаалаар батлагдсан "Гарал үүслийн гэрчилгээ олгох хяналт тавих журам" 4.5-д *"эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад олгосон талаарх мэдээллийг ойн ангийн дарга, сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан олгосон өдрөөс цахим сүлжээнд байрлуулна"* гэж заасан байна.

Ойн мэдээллийн цахим сайтад одоогийн байдлаар ойн сан бүхийн газрын талбай, түүний өөрчлөлт, ойн нөөц түүний өөрчлөлт, ойн түймрийн мэдээ гэх мэт батлагдсан 7 маягтаар мэдээлэл оруулсан бөгөөд эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгосон талаарх мэдээллийг огт оруулаагүй байна.

Энэ талаар аймгийн БОАЖГ-ын ойн албаны дарга Г. Цэнгэлзаяагаас тодруулахад *"Улсын хэмжээнд энэ асуудал яригдаж байгаа, одоогоор эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгосон талаарх мэдээллийг хэрхэн оруулах нь тодорхойгүй байгаа, хэрэв энэ асуудал шийдэгдвэл хэзээ ч, хаанаас цахим сайтаар хандаж эрхийн бичиг, гарал үүслийн олголтыг харах боломжтой болох учир түүнд тавих хяналт сайжирна."* гэсэн тайлбарыг өгсөн бөгөөд аймгийн БОАЖГ-аас эрхийн бичгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт шалгалт хийгддэггүй байна.

## АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Гүйцэтгэлийн аудитаар нийт **164,029.3 мянган төгрөгийн** зөрчил илэрснээс **1,925.6 мянган төгрөгийн** зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, **162,103.7 мянган төгрөгийн** зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж байна. Үүнд:

### **Төлбөрийн акт:**

- Ерөө бүсийн сум дундын ойн анги нь эрхийн бичгийн дүнг буруу бичсэнээс ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг 485.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн



- Хүдэр сумын Хангайн буудай ХХК нь 1,440.0 мянган төгрөгийн төлбөрийн орлогыг дутуу тушаасан.

### Албан шаардлага:

1.Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг ААН, нөхөрлөлтэй тооцоо нийлж, баталгаажуулаагүйгээс тайлант онд бичигдсэн эрхийн бичгийн дүнгээс 60,280.6 мянган төгрөгөөр илүү, 77,368.4 мянган төгрөгөөр дутуу төлөгдсөн байна. Үүнд:

- Ерөө сумын 15 ААН, нөхөрлөл 76,804.1 мянган төгрөгийг дутуу, 16 ААН, нөхөрлөл 40,526.2 мянган төгрөгийн илүү,
- Мандал сумын 9 ААН, нөхөрлөл 564.3 мянган төгрөгийг дутуу, 10 ААН, нөхөрлөл 5,747.2 мянган төгрөгийн илүү,
- Алтанбулаг сумын 3 ААН 1876.0 мянган төгрөгийг илүү,
- Цагааннуур сумын 3 ААН 7,737.5 мянган төгрөгийг илүү,
- Сайхан сумын 1 ААН 584.3 мянган төгрөгийг илүү,
- Баруунбүрэн сумын 1 ААН 1,999.5 мянган төгрөгийг илүү,
- Хүдэр сумын 2 ААН, нөхөрлөл 1809.9 мянган төгрөгийг илүү

2.Сумын ИТХ-аар батлагдсан ААН, нөхөрлөлтэй гэрээ байгуулахгүйгээр 3284.2 м3 буюу 24,454.7 мянган төгрөгийн мод бэлтгэх зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

- Баруунбүрэн сумын 2 ААН, 1 нөхөрлөл 329.2 м3 буюу 1,838.2 мянган төгрөг
- Ерөө сумын 5 ААН 2955 м3 буюу 22,616.5 мянган төгрөг

## ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



### СЭЛЭНГЭ АЙМАГ ХҮДЭР СУМЫН "ОЙН АНГИ" ОНӨААТҮГ

Сэлэнгэ аймаг, Хүдэр сум  
Утас: 9928-1130, 9033-3309

2017.07.03 № 32  
танай 2018.06.29 -ны № 83. -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИЙН ГАЗАР-Т

Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитийн газарт "Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа, манай ойн ангийн зүгээс нэмэлт тайлбар санал байхгүй болно.

ДАРГА  ТАЙВАНБААТАР



### СЭЛЭНГЭ АЙМАГ ХАРААГИЙН БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИ

Сэлэнгэ аймаг, Мандал сум  
Утас: 70367077, 93013707

2018.07.16 № 24  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ:


Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай:

Аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭНД хийж гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Үүнд:

1. 2017 оны ойгоос хэрэглээ, түлээний мод бэлтгэж ашигласны орлогын бүрдүүлэлтийг тасалдахад нөлөөлсөн зүйл нь "Малын гоц халдварт Шүлхий өвчин" гарч мод бэлтгэл явуулах хугацааг 2 сар зогсоосон.

ДАРГА  Р.НАРАН



  
**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
 ЦАГААННУУР СУМЫН СЭЛЭНГЭ  
 БЭЛЧИРИЙН БҮСИЙН СУМ  
 ДУНДЫН ОЙН АНГИ**  
 213200 Хуурч, Цагааннуур, Сэлэнгэ аймаг,  
 Утас: 99599389, 99505286

2018.07.06 № 13  
 танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
 ГАЗАР-Т**

Тус ойн ангийн хариуцсан сумдын ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн үр дүнгийн тайлангийн төсөлтэй бүрэн ихээр нь танилцлаа нэмэлт санал хүсэлт байхгүй болно.

ДАРГА  У.БАЯРСҮРЭН  


**СЭЛЭНГЭ АЙМАГ БАРУУНБҮРЭН  
 СУМАН ДАХЬ ОРХОН БҮСИЙН  
 СУМ ДУНДЫН ОЙН АНГИ**  
 Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум, Цагаан овоо 3-р баг  
 Утас: 93063782

2018.07.04 № 09  
 танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
 АУДИТЫН ГАЗАР-Т**

Тус сумын сум дундын ойн ангийн 2017 оны үнэт цаасны тайлан, үйл ажиллагаа, талбай тусгаарлалт, бусад анхан шатны холбогдох баримттай танилцан Сэлэнгэ аймгийн аудитын газраас гаргасан дүгнэлтэд нэмж оруулах санал байхгүй болно.

ДАРГА  БАЯН-ЭРДЭНЭ  


  
**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
 ЕРӨӨГИЙН БҮСИЙН  
 СУМ ДУНДЫН ОЙН АНГИ**  
 Сэлэнгэ аймаг, Ерөө сум  
 Утас: 99086068


2018.07.08 № 20  
 танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
 ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.  
 Тус ойн ангийн зүгээс нэмэлт тайлбар санал байхгүй болно.

ДАРГА  С.БАТ-АМГАЛАН  




Documents/Oin angi/A5

  
**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
 БАЙГАЛЬ ОРЧИН,  
 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**  
 213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг  
 Утас/Факс: (976)-7036-3653

2018.07.03 № 242  
 танай 2018.06.29-ны № 82-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
 АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР Ч.ЭНХТУЯА ТАНАА**

Танай 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн "Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.  
 Тайлангийн төслийн зөвлөмж хэсэгт аймгийн ойн менежмент төлөвлөгөөг боловсруулж байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, ойн сангаас бэлтгэх хэрэглээ, түлээний модны төлөвлөлтийг менежментийн төлөвлөгөөнд үндэслэн хийж байх гэсэн хэсэгтэй санал нийлэхгүй байна. Учир нь тус газар 2017 онд аймгийн ойн менежмент төлөвлөгөөг 5 жилийн хугацаагаар боловсруулан аймгийн Засаг даргаар баталгаажуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн боловч өдийг хүртэл батлагдаж ирээгүй байгаа нь ойн менежмент төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй гэсэн алдаа, дутагдал биш юм.  
 Иймд аймгийн Засаг даргад хандсан зөвлөмжийг хасуулах саналтай байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ТҮВШИНТӨГС  


Alban bichig /A-5/

## ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Аймгийн Засаг даргын зүгээс БОАЖЯ-нд 2017 онд аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны саналыг хүргүүлсэн боловч, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй, зарим сумдаас авсан санал нь холбогдох нотлох баримтаар нотлогдохгүй байна.
- Сумын ИТХ нь ойгоос бэлтгэх мод, түлээг аж ахуйн нэгж байгууллага тус бүрээр бус бөөн дүнгээр баталсан байна.
- Сумын ИТХ-аас ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар багт хуваарилсан модыг багийн Нийтийн хурал болон багийн Засаг даргын саналыг үндэслэлгүйгээр сумын Засаг даргын цохолтоор иргэдэд олгосон байна.
- Ерөө, Баруунбүрэн сумд нь мод бэлтгэх зарим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулаагүй байна.
- Ерөө сум ИТХ-аас баталсан хэмжээнээс илүү мод бэлтгүүлсэн болон ИТХ-аас батлагдаагүй аж ахуйн нэгжүүдэд мод бэлтгэх зөвшөөрөл олгосон байна.
- Сумдууд, ялангуяа Ерөө сум ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг урьдчилан төлүүлээгүйгээс их хэмжээний өглөг, авлагын тооцоо үүссэн бөгөөд, өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогыг зохих журмын дагуу үндэслэлтэй төлөвлөхгүй байгаагаас 2017 онд аймгийн хэмжээгээр бэлтгэх модны хэмжээ төлөвлөснөөс 35.2 хувиар буурсан байхад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 100.2 хувиар биелсэн байна.
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэх эрхийн бичгийн хөдлөл өөрчлөлт, түүнээс төвлөрөх орлогын гүйцэтгэлд хяналт, шалгалт хийгдэхгүй байна.
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний үлдэгдлийг ойн ангийн санхүүгийн тайланд тусгаагүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаад:**

- Дараа онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг “Ойгоос мод бэлтгэх журам”-д заасан хугацаанд багтаан батлах.

### **Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:**

- Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулж, түүнд үндэслэн ойн сангаас бэлтгэх хэрэглээний болон түлээний модны хэмжээг төлөвлөж байх.
- Сумдын ойгоос тод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч байх.
- Ерөө бүсийн сум дундын ойн ангийн үйл ажиллагаа, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ зэрэг үнэт цаасны бичилт, түүнээс төвлөрүүлэх татварын орлогын гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийж, дүнг Төрийн аудитын газарт мэдээлэх.

### **Аймгийн БОАЖГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч З.Түвшинтөгс-т:**

- Сумдын мод бэлтгэх саналыг журамд заасан шаардлагыг хангасан материалаар хүлээн авч, нэгтгэх.
- Сумдын ойн ангийн үнэт цаасны зарцуулалт, үлдэгдэл, төлбөрийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих, мэдээллийн санг бий болгож, архивлах.

### **Сумдын ИТХ-ын дарга нарт:**

- Сумын хэмжээнд бэлтгэх модны хэмжээг журамд заасны дагуу ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл бүрээр батлах, иргэдийн ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор бэлтгэх модыг багийн Засаг дарга болон ИНХ-ын саналыг үндэслэн хуваарилах.

### **Сумдын Засаг дарга нарт:**

- Ойгоос бэлтгэх модны саналыг журамд заасан, шаардлага хангасан материалын дагуу бэлтгэж, аймгийн Засаг даргад, хугацаанд нь хүргүүлж байх
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж байх.


### **Сум дундын болон сумын Ойн ангийн дарга нарт:**

- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны орлогын бүртгэлийг анхан шатны нэгж байгууллага бүрээр бүртгэн, түүнд тавих хяналтыг сайжруулах,

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлтийн үр дүн

- Сумдын байгаль хамгаалагчид олгосон эрхийн бичгийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан, тайлан мэдээг журамд заасан хугацаанд хүлээн авч, архивын нэгж үүсгэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА  
Б.БАТМӨНХ  
Ц.ОТГОНБАЯР  
С.БАТ-ЭРДЭНЭ  
Б.ЭРДЭНЭЗУЛ

Сэлэнгэ аймгийн 2017 онд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт

Зорилт	Огтлолын төрөл	Модны төрөл	Хэмжих нэгж	Төгсгөл /гегрөөр/	БОАЖЯ-нд хүргүүлсэн санал		Зөрүү	БОАЖС-ын 2016 оны 11-р сарын 23-ний өдрийн А/111 тушаалаар баталсан хуваарь		Зөрүү	Төгсгөл	БОАЖГ-аас Аймгийн ИТХ-д оруулсан санал	
					Тоо хэмжээ м3	Мөнгөн дүн		Тоо хэмжээ м3	Мөнгөн дүн			Тоо хэмжээ м3	Мөнгөн дүн
Үйдэрлэлийн	Хэрэглээ	Шинэс	м³	6720	19600	131712000	3100	16500	110880000	0	6720	16500	110880000
		Нарс	м³	8400	11500	96600000	3000	8500	71400000	0	8400	8500	71400000
		хус	м³	3900	5500	21450000	1000	4500	17550000	0	3900	4500	17550000
		Улиангар	м³		0	0	0	0	0	0	0	0	0
		<b>Дүн</b>	<b>м³</b>	<b>36600</b>	<b>249762000</b>	<b>7100</b>	<b>29500</b>	<b>199830000</b>	<b>29500</b>	<b>199830000</b>	<b>0</b>	<b>29500</b>	<b>199830000</b>
	Түлээ	Шинэс	м³	1920	4775	9168000	750	4025	7728000	0	1920	4025	7728000
		Нарс	м³	2400	2070	4968000	-530	2600	6240000	0	2400	2600	6240000
		хус	м³	1140	750	855000	-70	820	934800	0	1140	820	934800
		<b>Дүн</b>	<b>м³</b>	<b>7595</b>	<b>14991000</b>	<b>150</b>	<b>7445</b>	<b>14902800</b>	<b>0</b>	<b>7445</b>	<b>14902800</b>		
		<b>Бүгд</b>	<b>м³</b>	<b>44195</b>	<b>264753000</b>	<b>7250</b>	<b>36945</b>	<b>214732800</b>	<b>0</b>	<b>36945</b>	<b>214732800</b>		
Арилгааны огтлолт	Хэрэглээ	Шинэс	м³	5712	4400	25132800	1100	3300	18849600	0	5712	3300	18849600
		Нарс	м³	7140	5500	39270000	1600	3900	27846000	0	7140	3900	27846000
		Улиангар	м³	2856	80	228480	32	48	137088	-32	2856	80	228480
		Улиас	м³		0	0	0	0	0	0	0	0	
		хус	м³		0	0	0	0	0	0	0		
	<b>Дүн</b>	<b>м³</b>	<b>9980</b>	<b>64631280</b>	<b>2732</b>	<b>7248</b>	<b>46832688</b>	<b>-32</b>	<b>7280</b>	<b>46924080</b>			
	Түлээ	Улиангар	м³	1440	0	0	-32	32	46080	32	1440	0	0
		Шинэс	м³	1920	1030	1977600	0	1030	1977600	0	1920	1030	1977600
		Нарс	м³	2400	1405	3372000	0	1405	3372000	0	2400	1405	3372000
		хус	м³		0	0	0	0	0	0	0		
		Улиас	м³		0	0	0	0	0	0	0		
		Хуш /хуурай/	м³		0	0	0	0	0	0	0		
		<b>Дүн</b>	<b>м³</b>	<b>2435</b>	<b>5349600</b>	<b>-32</b>	<b>2467</b>	<b>5395680</b>	<b>32</b>	<b>2435</b>	<b>5349600</b>		
		<b>Бүгд</b>	<b>м³</b>	<b>12415</b>	<b>69980880</b>	<b>2700</b>	<b>9715</b>	<b>52228368</b>	<b>0</b>	<b>9715</b>	<b>52273680</b>		
		Цэвэрлэгээний огтлолт	Хэрэглээ	Улиангар	м³		0	0	0	0	0	0	0
Шинэс				м³	4988	12700	63347600	4600	8100	40402800	0	4988	8100
Нарс	м³			4988	27300	136172400	18750	8550	42647400	0	4988	8550	42647400
хус	м³			2324	1500	3486000	800	700	1626800	0	2324	700	1626800
Улиас	м³			2324	1100	2556400	900	200	464800	0	2324	200	464800
Хуш /хуурай/	м³		1092	5000	5460000	0	5000	5460000	0	1092	5000	5460000	
<b>Дүн</b>	<b>м³</b>		<b>47600</b>	<b>211022400</b>	<b>25050</b>	<b>22550</b>	<b>90601800</b>	<b>0</b>	<b>22550</b>	<b>90601800</b>			
Түлээ	Улиангар		м³		0	0	0	0	0	0	0	0	
	Шинэс		м³	1140	5000	5700000	4250	750	855000	0	1140	750	855000
	Нарс		м³	1140	7520	8572800	5160	2360	2690400	0	1140	2360	2690400
	хус		м³	570	350	199500	250	100	57000	0	570	100	57000
	Улиас		м³	570	2750	1567500	230	2520	1436400	0	570	2520	1436400
	Хуш /хуурай/		м³	1140	1000	1140000	0	1000	1140000	0	1140	1000	1140000
	<b>Дүн</b>		<b>м³</b>	<b>16620</b>	<b>17179800</b>	<b>9890</b>	<b>6730</b>	<b>6178800</b>	<b>0</b>	<b>6730</b>	<b>6178800</b>		
	<b>Бүгд</b>		<b>м³</b>	<b>64220</b>	<b>228202200</b>	<b>34940</b>	<b>29280</b>	<b>96780600</b>	<b>0</b>	<b>29280</b>	<b>96780600</b>		
	Цэвэрлэгээний ажил	Хэрэглээ	Улиангар	м³	1140	0	-190	190	216600	190	1140	0	0
			Шинэс	м³	3990	1300	5187000	0	1300	5187000	0	3990	1300
Нарс			м³	3990	11500	45885000	0	11500	45885000	0	3990	11500	45885000
хус			м³	1995	1600	3192000	0	1600	3192000	0	1995	1600	3192000
Улиас			м³	1995	1100	2194500	0	1100	2194500	0	1995	1100	3135000
Хуш /хуурай/		м³		0	0	0	0	0	0	0			
<b>Дүн</b>		<b>м³</b>	<b>15500</b>	<b>56458500</b>	<b>-190</b>	<b>15690</b>	<b>56675100</b>	<b>190</b>	<b>15500</b>	<b>57399000</b>			
Түлээ		Шинэс	м³	798	17500	13965000	0	17500	13965000	0	798	17500	13965000
		Нарс	м³	798	35300	28169400	0	35300	28169400	0	798	35300	28169400
		хус	м³	399	16550	6603450	0	16550	6603450	0	399	16550	6603450
		Улиас	м³	399	2700	1077300	0	2700	1077300	0	399	2700	1077300
		Улиангар	м³	399	1900	758100	190	1710	682290	-190	399	1900	758100
		Хуш /хуурай/	м³		0	0	0	0	0	0	0		
		<b>Дүн</b>	<b>м³</b>	<b>73950</b>	<b>50573250</b>	<b>190</b>	<b>73760</b>	<b>50497440</b>	<b>-190</b>	<b>73950</b>	<b>50573250</b>		
		<b>Бүгд</b>	<b>м³</b>	<b>89450</b>	<b>107031750</b>	<b>0</b>	<b>89450</b>	<b>107172540</b>	<b>0</b>	<b>89450</b>	<b>107972250</b>		
	Хэрэглээний мод	Нойтон хэрэглээ	Шинэс	м³		24000		4200	19800			19800	
			Нарс	м³		17000		4600	12400			12400	
хус			м³		5500		1000	4500			4500		
Улиас			м³		0		0	0			0		
Улиангар			м³		80		80	0			0		
Хуш /хуурай/			м³		0		0	0			0		
<b>Дүн</b>		<b>м³</b>	<b>46580</b>		<b>9880</b>	<b>36700</b>	<b>0</b>	<b>36700</b>		<b>36700</b>			
Хуурай хэрэглээ		Шинэс	м³		14000		4600	9400			9400		
		Нарс	м³		38800		18750	20050			20050		
		хус	м³		3100		800	2300			2300		
		Улиас	м³		2200		900	1300			1300		
		Улиангар	м³		0		-238	238			158		
		Хуш /хуурай/	м³		5000		0	5000			5000		
<b>Дүн</b>		<b>м³</b>	<b>63100</b>		<b>24812</b>	<b>38288</b>	<b>158</b>	<b>38130</b>		<b>38130</b>			
Хэрэглээний модны дүн		Шинэс	м³		38000		8800	29200			29200		
	Нарс	м³		55800		23350	32450			32450			
	хус	м³		8600		1800	6800			6800			
	Улиас	м³		2200		900	1300			1300			
	Улиангар	м³		80		-158	238			158			
	Хуш /хуурай/	м³		5000		0	5000			5000			
	<b>Дүн</b>	<b>м³</b>	<b>109680</b>		<b>34692</b>	<b>74988</b>	<b>158</b>	<b>74830</b>		<b>74830</b>			
<b>Түлээний модны дүн</b>	<b>м³</b>	<b>100600</b>		<b>10198</b>	<b>90402</b>	<b>-158</b>	<b>90560</b>		<b>90560</b>				
<b>Бүгд</b>	<b>м³</b>	<b>210280</b>		<b>44890</b>	<b>165390</b>	<b>0</b>	<b>165390</b>		<b>165390</b>				

Ерөө сумын 2017 оны мод бэлтгэлийн гүйцэтгэлийн тайлан

№	ААН, нөхөрлөлүүдийн нэр	2016 оны тооцоо	2017 оны тооцоо					2017.12.31-ны байдлаар
			Эрхийн бичгээр			төлөх ёстой дүн	төлсөн дүн-хуулгаар	
			хэрэглээ /м3/	түлээ /м3 /	мөнгөн дүн			
1	Алтан Солин	4,303,122.0	340	95	2,929,800.0	7,232,922.0	7,212,222.0	20,700.0
2	Бугант гол	53,346.0	980	100	10,192,200.0	10,245,546.0	16,221,231.0	(5,975,685.0)
3	Бугант Нандин	-	500	85	6,110,250.0	6,110,250.0	13,915,262.0	(7,805,012.0)
4	Бугант Минж	(546,025.0)	1118	146	10,785,330.0	10,239,305.0	11,343,250.0	(1,103,945.0)
5	Буян-Од	(491,569.0)	1163	50	10,676,850.0	10,185,281.0	18,876,431.0	(8,691,150.0)
6	Сэлэнгэ Бугант	(676,800.0)	600	100	5,881,500.0	5,204,700.0	7,300,800.0	(2,096,100.0)
7	Үзэсгэлэнт Бугант	-	350	75	3,571,200.0	3,571,200.0	4,363,642.0	(792,442.0)
8	Сосна	7,922,085.0	1090	105	13,106,550.0	21,028,635.0	17,694,500.0	3,334,135.0
9	ЭБНЗ	9,699,640.0				9,699,640.0		9,699,640.0
10	Ар Санжинт	1,949,550.0	628	92	4,750,230.0	6,699,780.0		6,699,780.0
11	Бугант номин	-	1182.5	382.5	10,632,750.0	10,632,750.0	8,286,750.0	2,346,000.0
12	Нугын хишиг	950,640.0	642.5	27.5	4,498,912.5	5,449,552.5	6,504,180.0	(1,054,627.5)
13	Мандал Оргил	(119,825.0)	1205	350	14,203,950.0	14,084,125.0	10,065,950.0	4,018,175.0
14	Түмэндалай	-	550	0	4,128,750.0	4,128,750.0	5,507,000.0	(1,378,250.0)
15	Номголжин	(523,718.0)	733	848	6,349,125.0	5,825,407.0	2,347,600.0	3,477,807.0
16	Цртг Манлай	(1,006,400.0)	734	286	7,444,920.0	6,438,520.0	9,293,750.0	(2,855,230.0)
17	Жаврай	-	635	65	5,067,000.0	5,067,000.0	5,370,000.0	(303,000.0)
18	УБТЗ-ын МБУ	-	2459.5	565.9	24,896,352.0	24,896,352.0	29,903,540.0	(5,007,188.0)
19	Өгөөж хараа	2,227,205.0	440	90	3,836,962.5	6,064,167.5		6,064,167.5
20	Сансар хараа	720,555.0	515	65	3,971,325.0	4,691,880.0	6,035,375.0	(1,343,495.0)
21	Баянсуудал шүтээн	-	785	145	6,033,900.0	6,033,900.0	5,910,635.0	123,265.0
23	Бишрэлт баян хангай	-				-		-
	ОЙН НӨХӨРЛӨЛ					-		-
24	Баянгол нөхөрлөл	-	100	0	631,900.0	631,900.0	1,021,987.0	(390,087.0)
25	Мөнх төгөл нөхөрлөл	1,480,575.0				1,480,575.0		1,480,575.0
28	Их Хөвч нөхөрлөл	1,356.0				1,356.0	927,665.0	(926,309.0)
29	Гурван гол нөхөрлөл	1,080,145.0				1,080,145.0		1,080,145.0
30	Улаанбулаг нөхөрлөл	262,195.0				262,195.0	356,250.0	(94,055.0)
31	Хөвч нөхөрлөл	-				-		-
32	Иргэд					-		-
	<b>ИТХ-ын тогтоолгүй мод бэлтгэсэн ААН</b>					-		-
1	<b>Номин од ХХК</b>	20,080,229.0	733	115	10,012,710.0	30,092,939.0		30,092,939.0
2	<b>Бугант говь ХХК</b>	1,432,125.0				1,432,125.0		1,432,125.0
3	<b>Иенбирс ХХК</b>	(86,850.0)	255	45	1,868,175.0	1,781,325.0	2,490,900.0	(709,575.0)
4	<b>Цант ажнай ХХК</b>	3,307,375.0	340	30	2,456,700.0	5,764,075.0		5,764,075.0
5	<b>Төгөлдөр хангай ХХК</b>	1,170,620.0				1,170,620.0		1,170,620.0
	<b>Нийт дүн</b>	<b>53,189,576.0</b>	<b>18,078.5</b>	<b>3,862.9</b>	<b>174,037,342.0</b>	<b>227,226,918.0</b>	<b>190,948,920.0</b>	<b>36,277,998.0</b>